



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАЙЛАНТ ОНУУДАД ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ
НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ БҮРЭН
ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: СЭА-2025/27-16-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум

2025.08.01

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Б.Батмөнх

Утас: 70363036, Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн

Утас: 70362442, Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com

Аудитор О.Анхбаяр

Утас: 70362442, Цахим хаяг: Ankhbayaro@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
Бүлэг А: Аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөөгүй байна.	5
А.1. Бусад салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, тогтоомжид торгуулийн орлогыг төлөвлөх талаар нарийвчлан тусгаагүй байна.	5
А.2. Аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож, төлөвлөөгүй байна.	6
А.3. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгууль нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байна.	8
Бүлэг Б: Зарим эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлого төсөвт бүрэн төвлөрөөгүй байна.	9
Б.1. Тайлант онуудад нийт 685.1 сая төгрөг (<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа нийт 38.4 сая төгрөгийг хасаж тооцсон.</i>) -ийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.	11
Б.2. Тайлант онуудад аймаг, сумд нь торгуулийн орлогын эх үүсвэрээс ГХУС зардалд журмын дагуу хуваарилаагүй байна.	11
Бүлэг В: Тайлант онуудад торгуулийн орлогоос зарцуулсан ГХУС үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байна.	13
В.1. Тайлант онуудад ГХУС арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.	15
В.2. Торгуулийн орлогын эх үүсвэрээр ГХУСАЗСЗ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ил тод, нээлттэй мэдээлээгүй байна.	18
Бүлэг Г: Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудын зүгээс үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	18
Г.1. Торгуулийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, ногдуулалт, бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	21
Г.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын газар болон иргэн, ТББ, ОУБ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.	23
Илрүүлсэн зөрчил	
Дүгнэлт	
Зөвлөмж	
Ирүүлсэн санал, тайлбар	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УЕП	Улсын Ерөнхий прокурор
УИХ	Улсын Их Хурал
ХЗДХС	Хууль, зүй дотоод хэргийн сайд
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

Хүснэгтийн товъёг

<i>Д/д</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Хүснэгт 1	<i>Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	7
Хүснэгт 2	<i>Торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлт</i>	12
Хүснэгт 3	<i>Торгуулийн орлогын нийт орлого болон татварын бус орлогод эзлэх хувь</i>	13
Хүснэгт 4	<i>Аймаг, сумдын ГХУС арга хэмжээний зардлын хуваарилалт</i>	14
Хүснэгт 5	<i>ГХУС арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	16
Хүснэгт 6	<i>ГХУС арга хэмжээний зардлын зарцуулалт</i>	17

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Хүү, торгуулийн 2023, 2024 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилго оршлоо. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: • Хүү, торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн үү? • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн үү? • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй байна уу? • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байна уу?
Аудитын хамарсан хүрээ:	Хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ болон бусад холбогдох байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад анхан шатны баримт материалуудыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ. Аудитад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэгч аймгийн Цагдаагийн газар, Мандал, Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс, ГИХГ-ын Хойд бүс дэх газар болон холбогдох бусад байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах,

	харьцуулах, нэгтгэх, баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглаж, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа.Үүнд: • Төрийн аудитын тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Татварын багц хууль, • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, • Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, • Авто замын тухай хууль, • Зөрчлийн тухай хууль, • Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, • Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, • Байгаль орчныг хамгаалах тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” • Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”, • Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”, • Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”, • Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор О.Анхбаяр, Р.Отгонжаргал нар 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:	Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нь аймаг, сумын торгуулийн орлогыг төлөвлөж, шат шатны ИТХ-аар батлуулсан бөгөөд 2023 онд 2,330.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,567.5 сая төгрөгийн, 2024 онд 3,908.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,675.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Тайлант онуудад аймгийн Цагдаагийн газар болон Сайхан, Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь 523.1 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 162.0 сая төгрөг, Татварын газар нь 36.1 сая төгрөг (<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа</i>), Гаалийн газар нь 2.3 сая төгрөг (<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа</i>) зэрэг нийт 723.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2023 онд 336.3 сая төгрөгөөр, 2024 онд 275.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөж, хуваарилсан байна.
--------------------------	--

Бүлэг А

Хүү, торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөөгүй байна.

А.1. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн үү?

Бусад салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, тогтоомжид торгуулийн орлогыг төлөвлөх талаар нарийвчлан тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.7-д “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.7.2-т “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, **хүү, торгуулийн орлого**”, 23.9-д “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9.2 дахь заалтад “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, **хүү, торгуулийн орлого**” гэж заасан байдаг.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29 дэх заалтад “Орон нутгийн төсвийн суурь орлого” гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг”, 58 дугаар зүйлийн 58.1-д “Энэ хуулийн 4.1.30-д заасан орон нутгийн төсвийн суурь зарлагыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ”, 58.1.1: “Аймаг, сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон, нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотын татварын болон татварын бус орлого” гэж заасан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 11.1.5: “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, **торгууль**” гэж заасны дагуу торгуулийн орлого бүрдүүлэхээр зохицуулсан байна.

Тайлант онуудад аймгийн хэмжээнд хүүгийн орлогыг төлөвлөөгүй зөвхөн торгуулийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитад хамрагдаж буй 2023 онд 53953 зөрчилд 3,021.9 сая төгрөгийн, 2024 онд 52982 зөрчилд 4,281.2 сая төгрөгийн торгууль ногдуулснаас үзэхэд уг орлогыг орон нутгийн төсвийн эх үүсвэр болгон урьдчилан тооцож, төлөвлөх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Торгуулийн орлого төвлөрүүлдэг бусад салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, тогтоомжид торгуулийн орлогыг төлөвлөх талаар нарийвчлан тусгасан зохицуулалт байхгүй байна.

А.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн, бодит нөхцөл байдлыг харгалзан төлөвлөсөн үү?

Аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож, төлөвлөөгүй байна.

Аймаг, сумын төсвийн орлогыг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д зааснаар төсвийн төсөлд орлогыг нэр, төрлөөр тооцож, төлөвлөхөөр зохицуулсан байдаг.

Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нь аймаг, сумын торгуулийн орлогыг төлөвлөж, шат шатны ИТХ-аар батлуулсан бөгөөд 2023 онд 2,330.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,567.5 сая төгрөгийн, 2024 онд 3,908.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,675.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №1

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумд	2020 он		2021 он		2022 он		2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Аймаг	300.0	313.8	600.0	451.7	750.0	261.3	750.0	388.4	1,750.0	844.8
2	Алтанбулаг	72.4	37.4	65.1	129.9	60.0	74.2	80.0	90.7	62.6	91.6
3	Баруунбүрэн	8.5	18.2	15.0	23.9	15.0	41.9	150.0	128.5	150.0	266.5
4	Баянгол	125.0	152.5	114.8	219.1	132.3	154.2	10.0	12.0	12.0	13.2
5	Ерөө	150.0	108.7	150.0	140.5	100.0	86.3	500.0	466.3	400.0	560.9
6	Зүүнбүрэн	9.5	10.3	15.0	14.6	20.0	13.6	16.5	64.2	55.0	23.8
7	Жавхлант	5.0	3.6	7.5	2.7	7.5	3.8	20.0	48.8	60.0	61.0
8	Мандал	320.0	356.9	340.0	431.8	400.0	549.1	20.0	53.4	40.0	22.4
9	Орхон	16.5	18.8	16.5	401.6	33.0	53.2	171.3	352.7	335.0	463.0
10	Орхонтуул	8.0	3.2	10.0	11.9	10.0	7.8	120.0	279.2	300.0	352.9
11	Сайхан	75.0	145.1	120.0	129.7	120.0	134.1	10.0	9.2	14.1	17.7
12	Сант	5.3	2.8	10.0	26.6	5.0	37.7	15.0	34.4	28.2	33.2
13	Сүхбаатар	230.0	282.8	185.6	306.0	243.1	306.2	100.0	189.3	220.0	306.0
14	Түшиг	10.0	10.0	10.0	5.0	10.0	8.1	45.0	24.5	25.0	45.3
15	Хушаат	10.0	0.4	0.1	0.1	5.0	0.5	280.0	377.6	380.0	484.2
16	Хүдэр	15.0	18.9	45.0	18.4	45.0	30.1	32.0	26.6	26.9	33.2
17	Цагааннуур	8.0	29.4	16.0	19.2	20.0	45.3	10.0	16.7	16.0	13.2
18	Шаамар	35.0	31.6	46.0	51.4	50.0	107.8	1.0	5.1	33.7	42.9
Нийт дүн		1,403.2	1,544.4	1,766.6	2,384.1	2,025.9	1,915.2	2,330.8	2,567.6	3,908.5	3,675.8

Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн, сумдын төсвийн ерөнхий нягтлан бодогч нараас тодруулга авахад торгуулийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцон төлөвлөж ирсэн гэх тайлбар өгсөн боловч 2023, 2024 онд аймаг, сумд үндэслэлгүйгээр дунджаас бууруулж, эсвэл нэмэгдүүлж төлөвлөсөн байна.Тухайлбал:

- Аймгийн 3 жилийн дундаж нь 2023 онд 342.3 сая төгрөг, 2024 онд 367.1 сая төгрөг бол 407.7-1,382.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж,
- Алтанбулаг сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 80.5 сая төгрөг, 2024 онд 98.3 сая төгрөг бол 35.7 сая төгрөгөөр бууруулж,
- Баруунбүрэн сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 28.0 сая төгрөг, 2024 онд 64.7 сая төгрөг бол 85.3-122.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж,
- Баянгол сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 175.3 сая төгрөг, 2024 онд 128.4 сая төгрөг бол 116.4-165.3 сая төгрөгөөр бууруулж,
- Ерөө сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 111.8 сая төгрөг, 2024 онд 231.0 сая төгрөг бол 169.0-388.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж,

- Мандал сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 445.9 сая төгрөг, 2024 онд 344.7 сая төгрөг бол 304.7-425.9 сая төгрөгөөр бууруулж,
- Орхон сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 157.8 сая төгрөг, 2024 онд 269.2 сая төгрөг бол 13.5-65.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж,
- Орхонтуул сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 7.6 сая төгрөг, 2024 онд 99.6 сая төгрөг бол 112.2-200.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Сүхбаатар сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 298.3 сая төгрөг, 2024 онд 267.2 сая төгрөг бол 47.2-198.3 сая төгрөгөөр бууруулж,
- Хушаат сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 0.3 сая төгрөг, 2024 онд 126.2 сая төгрөг бол 253.8-279.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж,
- Шаамар сумын 3 жилийн дундаж нь 2023 онд 63.6 сая төгрөг, 2024 онд 54.7 сая төгрөг бол 21.0-62.6 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн.

Дээрхээс үзэхэд торгуулийн орлогыг суурь судалгаанд үндэслэж, сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож төлөвлөөгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2.1.3 дахь “Суурь төсвийн саналд үндэслэн төсвийн төсөл боловсруулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2023 онд торгуулийн орлогын төлөвлөгөөг 236.8 сая төгрөгөөр давуулж, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна.

Харин 2024 онд торгуулийн орлого 232.7 сая төгрөгөөр тасарсан бөгөөд аймаг нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүй, сүүлийн 3 жилийн дунджаар тооцолгүйгээр хэт өндөр дүнгээр төлөвлөснөөс 905.2 сая төгрөгөөр тасарснаас голлон шалтгаалсан байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5¹-д заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан (цаашид ЭБАТ гэх) -тай байгууллагууд нь 2023, 2024 онд торгуулийн орлогыг төлөвлөөгүй байна.

Торгуулийн орлого бүрдүүлэгч эрх бүхий байгууллагууд нь өмнөх оны гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэн уг орлогыг төлөвлөхгүй байгаагаас төсвийн орлогын нэг эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлохгүй байгааг харуулж байна.

Торгууль нь эрх бүхий байгууллага, албан тушаалтныг нэг талаас “орлого бүрдүүлэгч” болгож, иргэн, аж ахуй эрхлэгч нарт торгуулийн дарамт үзүүлэх, ЭБАТ-уудад ашиг сонирхлын зөрчил үүсгэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа ч нөгөө талаас хууль тогтоомжийг хэрэгжүүлэх гол хөшүүрэг болж байна.

А.3. Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн байна уу?

Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгууль нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байна.

Торгууль нь орон нутгийн төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг боловч Төсвийн тухай хуульд уг орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалтын талаар тусгайлан

¹ Хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

заагаагүй, хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтныг тодорхойлоогүй байна.

Мөн “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.2.1², 4.2.2³-т төсвийн татварын орлогын төлөвлөлтийг тодорхойлсон атал татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, хуваарилалт хийх аргачлалын талаар тодорхой тусгаагүй байна.

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд шийтгэл ногдуулах эрх бүхий байгууллагуудын торгуулийн үндэслэл, хувь хэмжээг Зөрчлийн тухай хуулиар зохицуулсан байна.

Аймгийн хэмжээнд торгууль ногдуулах эрх бүхий 23 байгууллагын 360 ЭБАТ ажиллаж байгаа бөгөөд тухайн байгууллагууд нь өөр өөрсдийн салбарын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч ирсэн байна.

Аудитын нэгдсэн судалгааны дүнгээс үзэхэд ЭБАТ-ууд нь 2023 онд нийт 3,021.9 сая төгрөгийн 53953, 2024 онд нийт 4,281.2 сая төгрөгийн 52982 зөрчилд торгууль ногдуулснаас 9.1 сая төгрөгийн 5 торгуулийг хууль эрх зүйн үндэслэлгүй гэж үзэн аймгийн Шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон байна. Үүнийг тодруулбал:

- 2023 онд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3.0 сая төгрөг, Мал эмнэлгийн газрын 0.1 сая төгрөг зэрэг нийт 3.1 сая төгрөгийн 2 торгууль,
- 2024 онд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 5.5 сая төгрөгийн 2, Эрүүл мэндийн газрын 0.5 сая төгрөгийн 1 зэрэг нийт 6.0 сая төгрөгийн 3 гэх мэт.

Торгуулийн орлого бүрдүүлэх эрх зүйн үндэслэл нь Зөрчлийн тухай хууль дээр суурилж байгаа бөгөөд тухайн орлогыг төвлөрүүлдэг салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид орлого бүрдүүлэх асуудлыг нарийвчлан тусгаагүй байна.

Мөн торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, бүртгэл тайлагналын шатанд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй бөгөөд өнөөдрийн байдлаар торгууль ногдуулсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан хэрэгжилтийг хангуулж байна.

Торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зарим хууль тогтоомжийн заалтууд хоорондоо нийцээгүй болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нарийвчилсан асуудлыг тусгаагүй байна. Тухайлбал:

- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний

² Орон нутгийн төсвийн нийт орлогыг орон нутгийн төсвийн суурь орлого болон хуулиар эрх олгосны дагуу тухайн орон нутагт татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон орлогын нийлбэрээр

³ Орон нутгийн төсвийн суурь орлогыг тухайн шатны төсөвт орох Улсын Их Хурлаас тогтоосон татварын доод хувь, хэмжээгээр тооцсон татварын болон татварын бус орлогын нийлбэрээр

хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлэхээр зохицуулсан. Гэтэл Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.5.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, **орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд төвлөрүүлэх**” гэж заасантай нийцэхгүй,

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.3.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь **зөрчил хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана**” гэсэн заалт нь 1.8.1-д “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг **уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна**” гэж заасантай нийцэхгүй,
- Татварын ерөнхий хуульд татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, орлого бүрдүүлэх, татварын хөнгөлөлт, тайлагнах, хянан шалгах зэрэг бүхий л үйл ажиллагааг зохицуулсан атал хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт тавих талаар тодорхой тусгаагүй,
- Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдсэн этгээдэд торгууль ногдуулах, албадлагын арга хэмжээ авах асуудлыг тусгасан атал торгуулийн орлогыг бүрдүүлэх, төвлөрүүлэх асуудлыг ямар байгууллага, албан тушаалтан хариуцах талаар тодорхой тусгаагүй,
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8.6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ: 6.52. хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч” гэж заасан. Гэтэл Зөрчлийн тухай хуулийн 10.15-д Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчсөн зөрчилд тухайн ЭБАТ шийтгэл ногдуулахаар заасан атал Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нь шийтгэл ногдуулахын тулд заавал **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын байцаагчийн** хамт ажиллах шаардлагатай болох гэх мэт.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, жолоодох эрх нь дуусгавар болсон иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.7.1⁴-д заасны дагуу ижил хэмжээний торгууль ногдуулж байна. Өөрөөр хэлбэл шинж чанар, нийгэмд учруулах хор уршгийн хувьд ялгаатай зөрчилд ижил торгууль ногдуулж байгаа тул цаашид цахим хэлбэрээр бүртгэлийг хийж зөрчил гаргаагүй иргэдийн жолоодох эрхийг сунгах хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Харин Цагдаагийн газраас бэлэн бусаар ногдуулсан торгуулийг зарим иргэн төлөхгүй байгаа нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. УЕП, ХЗДХС-ын хамтарсан 2024 оны А/42, А/71 дугаар тушаалаар баталсан “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох, хугацаа, аргачлал”-ын 2.5-д зааснаар торгууль төлөөгүй этгээдийн оршин суугаа газарт эсхүл харьяа шүүхэд хүргүүлэх үүргийг ЭБАТ хариуцдаг нь хүндрэлтэй байна.

Иймд иргэд төрийн цахим үйлчилгээ авах үедээ өөрийн нэр дээр ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг мэдэгдлээр авах, мөн торгуулийн төлбөрөө төлөөгүй тохиолдолд зарим төрийн цахим үйлчилгээ авах эрхийг түр хугацаагаар

⁴ Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

хязгаарлах, төлбөрийг барагдуулсны дараа үйлчилгээг сэргээх зохицуулалтыг журамд тусгах шаардлагатай байна.

Аудитын нэгдсэн судалгааны дүнгээс үзэхэд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд торгууль ногдуулсан бөгөөд зөрчлийн хэлбэрээс нь хамаарч иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлт үзүүлэх талаар тусгаагүй бүх нийтэд тэгш үйлчлэх зохицуулалттай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.3⁵-т хүний эрхийн үндсэн баталгаа болох иргэний өмчлөх эрхийн халдашгүй байдлыг баталгаажуулж өгсөн атал Зөрчлийн тухай хуулийн 4.2.1, 4.2.3-т иргэний өмчийн халдашгүй байдалд нөлөөлөхөөр заалтууд тусгагдсан байна. Үүнд:

- *Зөрчлийн тухай хуулийн 4.2.1-д “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хэрэгслийг хураана”,*
- *Мөн хуулийн 4.2.3-т “Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй” гэх мэт.*

Дээрхээс үзэхэд иргэдийн амьжиргааны эх үүсвэртэй уялдуулж хөрөнгийг хураах, зарим тохиолдолд хураахгүй байх 2 өөр хэлбэрээр хуулийг хэрэглэх нөхцөл үүсгэсэн нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөж байна.

Бүлэг Б

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн үү?

Зарим эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлого төсөвт бүрэн төвлөрөөгүй байна.

Б.1. Ногдуулсан хүү, торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт хангагдсан уу?

Тайлант онуудад нийт 685.1 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 360 ЭБАТ зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аудитад хамрагдаж буй 2023, 2024 онд дээрх ЭБАТ-ууд холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд торгууль ногдуулсан байна. Үүнд:

- *2023 онд 3,021.9 сая төгрөгийн 53952 зөрчилд торгууль ногдуулснаас 2,567.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 131.4 сая төгрөгийг орлогыг улсын төсөвт, 3.4 сая төгрөгийг тухайн байгууллагын буюу нийгмийн даатгалын санд*

⁵ Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө.

төвлөрүүлсэн бол 319.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

- 2024 онд 4,281.2 сая төгрөгийн 52982 торгууль ногдуулснаас 3,675.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 197.8 сая төгрөгийг улсын төсөвт, 3.7 сая төгрөгийг тухай байгууллагын буюу нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн бол 403.9 сая төгрөгийн торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Тайлант онуудын торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлтийг дараах хүснэгтээр харуулбал:

Торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлт

Хүснэгт №2		/сая төгрөгөөр/											
№	Байгууллага	2023 он						2024 он					
		Ногдуулсан	Зөрчлийн тоо	Төвлөрүүлсэн			Зөрүү	Ногдуулсан	Зөрчлийн тоо	Төвлөрүүлсэн			Зөрүү
				Орон нутгийн төсөв	Улсын төсөв	Тухайн байгууллагад				Орон нутгийн төсөв	Улсын төсөв	Тухайн байгууллагад	
1	Аймгийн Цагдаагийн газар	1,811.4	52322	1,559.5	-	-	(251.9)	1,575.8	51515	1,304.6	-	-	(271.2)
2	Аймгийн Эрүүл мэндийн газар	2.7	2	-	2.7	-	-	59.6	30	-	59.6	-	-
3	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	31.6	13	31.3	0.3	-	-	40.3	23	40.3	-	-	-
4	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	183.0	89	118.4	-	-	(64.6)	107.3	42	9.9	-	-	(97.4)
5	Аймгийн Мал эмнэлгийн газар	1.5	6	0.2	1.3	-	-	0.3	2	-	0.3	-	-
6	Аймгийн Байгаль орчны газар	51.6	44	51.6	-	-	-	170.4	62	170.4	-	-	-
7	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	21.1	790	21.1	-	-	-	13.7	479	13.7	-	-	-
8	Түжийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	-	0	-	-	-	-	1.0	2	1.0	-	-	-
9	Сэлэнгэ аймгийн Авто тээврийн төв	63.0	91	63.0	-	-	-	52.0	70	52.0	-	-	-
10	ГИХ-ын Хойд бүс дэх газар	52.4	216	52.4	-	-	-	71.9	270	71.9	-	-	-
11	Аймгийн Боловсролын газар	-	0	-	-	-	-	0.1	1	0.1	-	-	-
12	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	4.7	11	-	4.7	-	-	3.8	10	0.8	3.0	-	-
13	Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар	114.4	235	-	114.4	-	-	127.2	340	-	124.9	-	(2.3)
14	Аймгийн Нийгмийн даатгалын газар	3.4	15	-	-	3.4	-	3.7	5	-	-	3.7	-
15	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын салбар	1.5	2	-	1.5	-	-	4.5	7	-	4.5	-	-
16	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	6.5	19	-	6.5	-	-	5.5	27	-	5.5	-	-
17	Аймгийн Онцгой байдлын газар	1.7	4	1.7	-	-	-	3.4	6	3.4	-	-	-
18	Аймгийн Татварын газар	190.9	93	187.8	-	-	(3.1)	401.0	91	368.0	-	-	(33.0)
19	Бусад байгууллага	480.5	-	480.5	-	-	-	1,639.7	-	1,639.7	-	-	-
Нийт дүн		3,021.9	53952	2,567.5	131.4	3.4	(319.6)	4,281.2	52982	3,675.8	197.8	3.7	(403.9)

Дээрхээс үзэхэд 2023, 2024 онд эрх бүхий дараах 4 байгууллага, албан тушаалтны ногдуулсан нийт 723.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1⁶, 7.5.8⁷ -д заасантай тус тус нийцэхгүй байна. Үүнийг тодруулбал:

- Аймгийн Цагдаагийн газар нь 2023 онд 6737 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 251.9 сая төгрөгийг, 2024 онд 9269 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 271.2 сая төгрөгийг,
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2023 онд 9 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 64.6 сая төгрөгийг, 2024 онд 1 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 97.4 сая төгрөгийг,
- Аймгийн Татварын газар 2023 онд 8 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 3.1 сая төгрөгийг, 2024 онд 5 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 33.0 сая төгрөг (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа) -ийг,

⁶ Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна.

⁷ Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

- Гаалийн газар нь 2024 онд 4 зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 2.3 сая төгрөг (Хуулийн байгууллагад шилжүүлсэн) -ийг тус тус төвлөрүүлээгүй.

Иймээс дээрх эрх бүхий байгууллагуудын ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Эрх бүхий албан тушаалтнуудын 2023, 2024 онд ногдуулсан нийт 329.2 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ” 23.7.2: “... , **хүү, торгуулийн орлого**” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймаг, сумд нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал”-ын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод “Хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнаж ирсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хүү, торгуулийн орлогыг 2023 онд 2,330.8 сая төгрөгөөр төлөвлөж, 2,567.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2024 онд 3,908.5 сая төгрөгөөр төлөвлөж, 3,675.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг татварын орлогын гүйцэтгэлтэй тулган шалгахад зөрүүгүй, үнэн зөв тайлагнасан байна.

Торгуулийн орлого нь 2023, 2024 онд орон нутгийн нийт орлогын 3.1 хувийг, нийтлэг татварын бус орлогын 39.4-44.8 хувийг тус тус эзэлж байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Нийт орлого болон татварын бус орлогод эзлэх хувь

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумд	2023 он					2024 он				
		Торгуулийн орлогын гүйцэтгэл	Нийт орлогын гүйцэтгэл	Торгуулийн орлогын эзлэх хувь	Нийтлэг татварын бус орлогын гүйцэтгэл	Торгуулийн орлогын эзлэх хувь	Торгуулийн орлогын гүйцэтгэл	Нийт орлогын гүйцэтгэл	Хүү торгуулийн орлогын эзлэх хувь	Нийтлэг татварын бус орлогын гүйцэтгэл	Торгуулийн орлогын эзлэх хувь
1	Аймаг	388.4	26,368.4	1.5	1,078.2	36.0	844.8	43,753.0	1.93	1,661.9	50.8
2	Алтанбулаг	90.7	1,142.6	7.9	197.2	46.0	91.6	1,693.5	5.41	189.6	48.3
3	Баруунбүрэн	34.4	1,224.4	2.8	161.6	21.3	33.2	1,993.4	1.67	246.7	13.5
4	Баянгол	352.7	2,788.8	12.6	586.0	60.2	463.0	4,449.9	10.40	609.4	76.0
5	Ерөө	128.5	8,888.3	1.4	360.9	35.6	266.5	9,515.0	2.80	752.1	35.4
6	Жавхлант	26.6	669.3	4.0	83.1	32.0	33.2	890.3	3.73	57.7	57.5
7	Зүүнбүрэн	11.9	977.6	1.2	78.3	15.2	13.2	1,389.6	0.95	114.2	11.6
8	Мандал	466.3	12,585.7	3.7	1,179.8	39.5	560.9	17,469.6	3.21	1,059.1	53.0
9	Орхон	64.2	981.8	6.5	183.1	35.1	23.8	1,292.4	1.84	195.9	12.1
10	Орхонтуул	9.2	1,334.4	0.7	79.3	11.6	17.7	2,621.8	0.68	90.0	19.7
11	Сайхан	279.2	4,971.0	5.6	430.0	64.9	352.9	6,505.7	5.42	495.1	71.3
12	Сант	48.8	780.6	6.3	92.0	53.0	61.0	991.1	6.15	120.3	50.7
13	Сүхбаатар	377.6	10,239.4	3.7	570.7	66.2	484.2	15,807.4	3.06	683.9	70.8
14	Түшиг	16.7	1,264.1	1.3	161.4	10.3	13.2	1,449.1	0.91	72.8	18.1
15	Хушаат	5.1	851.2	0.6	40.6	12.6	42.9	1,303.5	3.29	138.5	31.0
16	Хүдэр	24.5	3,765.3	0.7	776.4	3.2	45.3	3,930.2	1.15	1,164.4	3.9
17	Цагааннуур	53.4	2,562.8	2.1	186.3	28.7	22.4	2,540.3	0.88	132.5	16.9
18	Шаамар	189.3	1,155.9	16.4	304.3	62.2	306.0	1,771.6	17.27	424.2	72.1
Нийт дүн		2,567.5	82,551.6	3.1	6,549.2	39.2	3,675.8	119,367.4	3.1	8,208.3	44.8

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд торгуулийн орлого нь нийт орлогын гүйцэтгэлд 3.1 хувийг эзэлж байгаа нь нийт төсвийн орлогын хэмжээнд шууд нөлөө үзүүлэхгүй байгааг харуулж байна.

Харин нийтлэг татварын бус орлогын 39.2-44.8 хувийг эзэлж байгаа нь торгуулийн орлого татварын бус орлогын бүрэлдэхүүн хэсэг болохыг тодорхойлж байгаа бөгөөд уг орлогын өсөлт, бууралт нь татварын бус орлогын гүйцэтгэлд шууд нөлөө үзүүлж байна.

Өөрөөр хэлбэл торгуулийн орлогын гүйцэтгэл өссөн тохиолдолд татварын бус орлогын биелэлт нэмэгдэж, орон нутгийн төсвийн санхүүжилт нэмэгдэх, буурсан тохиолдолд бусад орлогын эх үүсвэрээр нөхөх шаардлага үүсэх, улмаар төлөвлөгөө тасрах торгуулийн орлогоор санхүүлэх зардлын санхүүжилт буурах эрсдэлийг дагуулж байна.

Ихэнх төрийн байгууллагын удирдлагууд нь албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд ногдуулсан болон төвлөрүүлсэн торгуулийн орлогын биелэлтийг харгалзан үздэггүй нь ЭБАТ-ны ажлын гүйцэтгэл, хариуцлагыг бууруулах эрсдэлийг дагуулж байна.

Иймээс ЭБАТ-ны ногдуулсан болон төвлөрүүлсэн торгуулийн орлогын биелэлтийг ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд харгалзан үзэх зохицуулалт оруулах шаардлагатай байна.

Б.2. Хүү, торгуулиас бүрдсэн орлогыг хууль, журмын дагуу хуваарилсан уу?

Тайлант онуудад аймаг, сумд нь торгуулийн орлогын эх үүсвэрээс ГХУС арга хэмжээний зардалд журмын дагуу хуваарилаагүй байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам” -д замын хөдөлгөөний болон хэв журам зөрчсөн зөрчилд ногдуулсан торгуулийн орлогын 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (цаашид ГХУС гэх) зардалд хуваарилахаар зохицуулсан байдаг.

Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нар өмнөх оны торгуулийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан ГХУС арга хэмжээний зардлыг төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэрийг шат шатны ИТХ-аар батлуулсан байна.

Аймгийн хэмжээнд ГХУС арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2023 онд 336.3 сая төгрөгөөр, 2024 онд 275.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөж, хуваарилсан байна. Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁸ дэх заалттай нийцэхгүй байна.

⁸ ... зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

Аймаг, сумдын ГХУС арга хэмжээний зардлын хуваарилалтыг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4		/сая төгрөгөөр/									
№	Аймаг, сумд	Торгуулийн орлогын гүйцэтгэл		ГХУС зардалд 40 хувиар тооцвол зохих дүн		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал				ГХУС зардлыг илүү, дутуу тооцсон	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2023 он		2024 он		2023 он	2024 он
						Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Аймаг	261.3	388.4	104.5	155.4	220.0	219.7	482.0	481.6	115.5	326.6
2	Алтанбулаг	74.2	90.7	29.7	36.3	11.8	6.9	5.0	5.0	(17.9)	(31.3)
3	Баруунбүрэн	41.8	34.4	16.7	13.8	-	-	1.5	1.5	(16.7)	(12.3)
4	Баянгол	154.2	352.7	61.7	141.1	2.0	2.0	5.0	4.5	(59.7)	(136.1)
5	Ерөө	86.2	128.5	34.5	51.4	5.0	5.0	2.0	2.0	(29.5)	(49.4)
6	Жавхлант	13.6	26.6	5.4	10.6	10.0	10.0	7.0	7.0	4.6	(3.6)
7	Зүүнбүрэн	3.8	11.9	1.5	4.8	25.0	25.0	50.0	50.0	23.5	45.2
8	Мандал	549.1	466.3	219.6	186.5	20.0	19.8	20.0	9.3	(199.6)	(166.5)
9	Орхон	53.2	64.2	21.3	25.7	2.0	2.0	12.0	12.0	(19.3)	(13.7)
10	Орхонтуул	7.8	9.2	3.1	3.7	14.2	14.1	10.0	8.0	11.1	6.3
11	Сайхан	134.1	279.2	53.6	111.7	2.0	1.5	2.0	1.9	(51.6)	(109.7)
12	Сант	37.7	48.8	15.1	19.5	3.0	3.0	5.0	4.8	(12.1)	(14.5)
13	Сүхбаатар	306.2	377.6	122.5	151.0	-	-	5.0	5.0	(122.5)	(146.0)
14	Түшиг	8.1	16.7	3.2	6.7	4.0	3.9	2.0	2.0	0.8	(4.7)
15	Хушаат	0.5	5.1	0.2	2.0	9.0	9.0	-	-	8.8	(2.0)
16	Хүдэр	30.1	24.5	12.0	9.8	1.5	0.7	3.0	2.4	(10.5)	(6.8)
17	Цагааннуур	45.3	53.4	18.1	21.4	60.0	58.1	60.0	59.5	41.9	38.6
18	Шаамар	107.8	189.3	43.1	75.7	40.0	38.2	80.0	80.0	(3.1)	4.3
Нийт дүн		1,915.0	2,567.5	765.8	1,027.1	429.5	418.9	751.5	736.5	(336.3)	(275.6)

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрхээс үзэхэд аймаг нь ГХУС арга хэмжээний зардлыг өмнөх оны гүйцэтгэлийн 40 хувиар буюу 2023 онд 155.0 сая төгрөгөөр, 2024 онд 155.4 сая төгрөгөөр тооцож, санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилах ёстой. Гэтэл 2023 онд 220.0 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 219.7 сая төгрөгийг хуваарилсан бол 2024 онд 482.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 481.6 сая төгрөгийг хуваарилсан байна.

Жавхлант, Зүүнбүрэн, Орхонтуул, Түшиг, Хушаат, Цагааннуур зэрэг 6 сум нь ГХУС арга хэмжээний зардлыг өмнөх оны гүйцэтгэлийн 40 хувиар бус 0.8-41.9 сая төгрөгөөр илүү хуваарилсан бол бусад 11 сум нь 3.1-199.6 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь ГХУС арга хэмжээний зардалд торгуулийн орлогын 40 хувиар тооцож санхүүжилтийг төлөвлөж, хуваарилсан эсэхэд үр нөлөө бүхий хяналт хэрэгжүүлээгүйгээс Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

Бүлэг В

Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй байна уу?

Тайлант онуудад торгуулийн орлогоос зарцуулсан ГХУС үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байна.

В.1. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан уу?

Тайлант онуудад ГХУС арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ (цаашид ГХУС гэх) -ний зардалд аймгийн хэмжээнд 2023 онд 429.5 сая төгрөг, 2024 онд 751.5 сая төгрөгийг зарцуулахаар баталж 2023 онд 418.9 сая төгрөг, 2024 онд 736.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүний дараах хүснэгтээр харуулбал:

ГХУС арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумдын нэр	2023		2024	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Аймаг	220.0	219.7	482.0	481.6
2	Алтанбулаг	11.8	6.9	5.0	5.0
3	Баруунбүрэн	5.0	5.0	2.0	2.0
4	Баянгол	25.0	25.0	50.0	50.0
5	Ерөө	20.0	19.8	20.0	9.3
6	Жавхлант	2.0	2.0	12.0	12.0
7	Зүүнбүрэн	3.0	3.0	5.0	4.8
8	Мандал	60.0	58.1	60.0	59.5
9	Орхон	2.0	2.0	5.0	4.5
10	Орхонтуул	2.0	1.5	2.0	1.9
11	Сайхан	14.2	14.1	10.0	8.0
12	Сант	-	-	1.5	1.5
13	Сүхбаатар	40.0	38.2	80.0	80.0
14	Түшиг	1.5	0.7	3.0	2.4
15	Хушаат	-	-	5.0	5.0
16	Хүдэр	10.0	10.0	7.0	7.0
17	Цагааннуур	4.0	3.9	2.0	2.0
18	Шаамар	9.0	9.0	-	-
Нийт дүн		429.5	418.9	751.5	736.5

Дээрх хүснэгтээс харахад ГХУС зардлын гүйцэтгэлийн 60.7 хувийг аймгийн ИТХ-ын төсөвт баталж, зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалт 2023 оноос 317.6 сая төгрөгөөр буюу 43.1 хувиар өссөн бөгөөд нийт зарцуулалтын дийлэнх хувийг тоног төхөөрөмж худалдан авах, сургалт, сурталчилгаа хийх зэрэг зардлуудад зарцуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

ГХУС арга хэмжээний зардлын зарцуулалт

Хүснэгт №6

/сая төгрөгөөр/

№	Зардлын төрөл	2023 он	2024 он	Нийт
1	ГХУСАЗСЗ болон ОНЦ-ийн цалин, урамшуулал	63.0	91.9	154.9
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа	67.3	188.2	255.5
3	Тоног төхөөрөмж худалдан авах	145.7	225.2	370.9
4	Шатахууны зардал	36.9	39.0	75.9

5	Замын тэмдэг тэмдэглэгээ сайжруулах	33.3	55.8	89.1
6	Өмгөөллийн зардал	9.1	10.8	19.9
7	Бусад зардал	63.6	125.6	189.2
	Нийт дүн	418.9	736.5	1,155.4

Дээрх хүснэгтээс харахад ГХУС зардлын зарцуулалтын 370.9 сая төгрөг буюу 32.1 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад, 255.5 сая төгрөг буюу 22.1 хувийг сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад, 154.9 сая төгрөг буюу 13.4 хувийг ГХУСАЗСЗ болон олон нийтийн цагдаагийн цалин, урамшууллын зардалд зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.4⁹ дэх хэсэгт заасны дагуу аймаг, сумдын ГХУС зардлаас гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудад 2024 онд 145.7 сая төгрөгийн 2024 онд 225.2 сая төгрөгийн зэрэг нийт 370.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- *Аймгийн Цагдаагийн газарт 233.1 сая төгрөг,*
- *Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэст 104.9 сая төгрөг,*
- *Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 24.9 сая төгрөг,*
- *Хилийн цэргийн 0101 дүгээр ангид 5.6 сая төгрөг*
- *Аймгийн Шүүхийн Тамгын газарт 2.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж гэх мэт.*

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг шат шатны ИТХ-ын төрийн сангийн дансаар дамжуулан ГХУС (82201) кодтой арга хэмжээн дээр төлөвлөж, зарцуулсан байна. Гэвч уг зардлыг аймаг болон 10 сумын ИТХ нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801)-ийн зардлын ангилал дээр, 7 сумын ИТХ нь бараа үйлчилгээний бусад зардал (210901)-ын ангилал дээр бөөн дүнгээр төлөвлөж, зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулж буй зардлыг нэг эдийн засгийн ангиллын хүрээнд бөөн дүнгээр төлөвлөж, зарцуулж байгаа нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

Иймд ГХУС арга хэмжээний хүрээнд гаргах зардлыг эдийн засгийн зардлын ангилал тус бүрээр нарийн төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2023, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар 79.8 сая төгрөгийн зөрчлүүд илэрч албан шаардлага өгснөөр зөрчлийг арилгуулсан байна. Үүнд:

- *Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан 8.0 сая төгрөг,*
- *Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн 5.1 сая төгрөг,*
- *Санхүүгийн тайланд авлага, өглөгөөр бүртгээгүй 27.3 сая төгрөг,*

⁹ гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх

- *Сургалт, хэлэлцүүлгийн ажил хийж гүйцэтгэсэн гэрээг дүгнээгүй 39.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон гэх мэт.*

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад нийт 46 төрлийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулж давхардсан тоогоор 33,059 иргэнийг хамруулсан байна. Мөн цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр салбар зөвлөлийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийг сурталчилж давхардсан тоогоор 121,668 иргэнд хүргэж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2020-2024 онуудад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээг Үндэсний статистикийн хорооны 1212.mn сайтаас авч үзэхэд:

- 2020 онд 549 зөрчил бүртгэгдсэн бол 2021 онд өмнөх оноос 88-аар нэмэгдэж 637, 2022 онд 138-аар нэмэгдэж 775 бүртгэгдсэн,
- 2023 онд өмнөх оноос 49-өөр буурч 726 бүртгэгдсэн бол 2024 онд 19.8 хувиар буюу 144-өөр нэмэгдэж 870 зөрчил бүртгэгдсэн байна.

Тайлант онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн сургалтын тоо, иргэдийн оролцоо нэмэгдсэн, арга хэмжээний зардал 2020 онд 204.4 сая төгрөгөөс 2024 онд 736.5 сая төгрөг болж 3.6 дахин нэмэгдсэн боловч гэмт хэрэг, зөрчил буураагүй, үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байна.

В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна уу?

Торгуулийн орлогын эх үүсвэрээр ГХУСАЗСЗ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ил тод, нээлттэй мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд аймаг сумдын ИТХ-ын төсөвт батлагдсан ГХУС арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, холбогдох тушаал, шийдвэрийг бүрэн мэдээлж ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ, ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг аймаг, сумдын ИТХ нь өөрсдийн цахим хаяг (фэйсбүүк), www.selenge.khural.mn сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн боловч зөвлөлийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, хүү торгуулийн орлогын зарцуулалтын тайланг тухайн шатны ИТХ-ын төлөөлөгчид болон Монгол улсад ГХУС ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулж, хүргүүлснээс өөрөөр олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлд жил бүр хийдэг санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт өгснөөс бусад тохиолдолд хүү, торгуулийн орлогын зарцуулалт, ил тод байдалд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудын зүгээс үнэлгээ өгч санал хүргүүлээгүй байна.

Бүлэг Г

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байна уу?

Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудын зүгээс үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Г.1. Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байна уу?

Торгуулийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, ногдуулалт, бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар торгууль ногдуулах ЭБАТ-ны ногдуулсан торгуулийн мэдээллийг Цагдаагийн байгууллага, Татварын алба, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг зарим төрийн байгууллагууд нь тус тусын мэдээллийн системээр бүртгэж, биелэлтэд дотоод хяналт тавьж ирсэн байна.

Гэвч дээрх байгууллагуудын мэдээллийн системүүд хоорондоо уялдаа холбоогүй, өгөгдлийн нэгдсэн сан үүсгээгүй, харилцан мэдээлэл солилцох боломжгүй байгаа нь торгуулийн шийдвэрлэлт, хяналт-шинжилгээ, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулж байна.

Түүнчлэн дээрх байгууллагуудаас бусад торгууль оногдуулах эрх бүхий төрийн байгууллагууд нь ногдуулсан торгуулийн мэдээллээ системтэйгээр бүртгэдэг мэдээллийн сан бүрдүүлээгүй, цаасан хэлбэрээр хязгаарлагдмал байдлаар хадгалж байгаа нь бүртгэл, хяналтын үр нөлөөг бууруулж байна.

Аймаг, сумдын төрийн сангийн хувьд тайлант хугацаанд аль байгууллагаас ямар хэмжээний торгууль, хэзээ ногдуулсан зэрэг мэдээллийг бүрэн авч чадахгүй байгаа нь торгуулийн орлогын төлөвлөлтийг үнэн зөв, бодитой хийхгүй байх, орлогын бүрдэлтэд үр дүнтэй хяналт хэрэгжүүлэхгүй байх, төсвийн орлого тасрах зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна.

Иймд Монгол улсын хэмжээнд торгуулийн мэдээллийн бүртгэлийг нэгтгэх, эрх бүхий байгууллагуудын ногдуулсан торгуулийн шийдвэр, биелэлтийн явцыг нэгдсэн байдлаар хянах боломжтой бүртгэлийн системийг нэвтрүүлж, цахим мэдээллийн сантай болох зайлшгүй шаардлагатай байна.

Торгуулийн орлогын бүртгэлийн нэгдсэн цахим санг нэвтрүүлснээр дараах нааштай үр дагаврууд бий болох боломжтой. Үүнд:

- Орлого бүрдүүлэлт сайжирч, төсвийн алдагдлыг бууруулах нөхцөл бүрдэнэ
- Ил тод байдал, хариуцлага дээшилнэ
- Бодлого, төлөвлөлт, дүн шинжилгээний чанар сайжирна
- Авлигын эрсдэлийг бууруулна

Торгуулийн орлогын бүртгэл, хяналтын тогтолцоонд технологийн дэвшлийг ашиглан нэгдсэн цахим санг бүрдүүлэх нь зардлын хяналт, орлогын төлөвлөлт,

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

бодлогын шийдвэр гаргалтад үнэтэй суурь мэдээлэл болох төдийгүй, иргэдийн оролцоог хангах чухал ач холбогдолтой юм.

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлсэн үү?

Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын газар болон иргэн, ТББ, ОУБ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

Дээрх чиг үүргийн хүрээнд аймгийн төрийн сангийн дансанд төвлөрсөн дүнгээр буюу зөвхөн орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа нь ногдуулсан торгуулийн орлогын биелэлт, хугацаа хэтэрсэн эсэхэд ЭБАТ-ны хяналт орхигдсон, хяналтын нэгдсэн цахим систем дутагдалтай байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.13¹⁰, 2.14¹¹-т заасны дагуу шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудсыг эрх бүхий байгууллагад олгох, мэдээ, тайланг хүлээн авч, тооцоо нийлж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хүргүүлж байна.

Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ыг баталсан 2.2¹², 2.12¹³-т заасны дагуу эрх бүхий байгууллага нь “шийтгэлийн хуудас”-ыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилж, бүртгэл, хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч нар хяналт тавих чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд ногдуулсан торгуулийн орлогын бүрдүүлэлтэд эрх бүхий байгууллагуудаас дотоод хяналт хэрэгжүүлээгүйн улмаас торгуулийн орлого орон нутгийн төсөвт бүрэн төвлөрөөгүй байна.

Эрх бүхий байгууллагуудын зүгээс улсын байцаагчийн ногдуулсан торгуулийн орлогыг хянах тогтолцоо бүрдээгүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх

¹⁰ Эрх бүхий байгууллага нь жил, хагас жил тутам аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгж эсхүл холбогдох дээд шатны байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хүргүүлж баталгаажуулна.

¹¹ Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгж, эрх бүхий байгууллага нь жил бүр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хийнэ.

¹² Шийтгэлийн хуудсыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн хэвлүүлж, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгжид албан хүсэлтийн дагуу бүртгэлээр олгох бөгөөд түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт, зарцуулалтад тухайн эрх бүхий байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавина.

¹³ Эрх бүхий албан тушаалтан шийтгэлийн хуудасны тооцоог сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон шийтгэлийн хуудсыг олгох, тайлан, тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтантай хийж, тухайн байгууллагын ахлах нягтлан бодогч хяналт тавьж, улирал бүр удирдлагад танилцуулж баталгаажуулна.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.1¹⁴-д заасны дагуу тухайн ЭБАТ өөрөө хариуцан ажиллаж байна.

Тайлант онуудад торгуулийг нөхөн төлүүлэх арга хэмжээг авч байгаа боловч иргэдийн шилжилт хөдөлгөөн их, хүргүүлсэн мэдэгдэл зөрчил гаргасан иргэнд хүрдэггүй, тээврийн хэрэгслийн ашиглалт идэвхгүй байгаа зэргээс шалтгаалж дараах 2 эрх бүхий байгууллагаас ногдуулсан торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байна. Үүнд:

- *Аймгийн Цагдаагийн газар болон Мандал, Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь бэлэн бусаар ногдуулсан нийт 523.1 сая төгрөгийн,*
- *Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь нийт 162.0 сая төгрөгийн зэрэг.*

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс торгуулийн орлогын зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байгаа хэдий ч ГХУС арга хэмжээний зардлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэх ажил хангалтгүй байна.

Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудаас дараах хяналт шалгалтын ажлыг хийсэн Үүнд:

- *Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар хяналт хэрэгжүүлсэн.*
- *Аймгийн Засаг даргын 2024 оны А/75 дугаар захирамжаар байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар ахлуулсан “Ажлын хэсэг” нь хяналт шалгалт хийсэн.*
- *Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023, 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд ГХУС зардлын зарцуулалтад дотоод хяналт хийсэн байна.*

Тайлант онуудад торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар болон иргэн, Төрийн бус байгууллага, ОУБ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

¹⁴ Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **1,297.0** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

- Тайлант онуудад ЭБАТ-ны ногдуулсан нийт 685.1 сая төгрөг (*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа нийт 38.4 сая төгрөгийг хасаж тооцсон.*) -ийн торгуулийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн.
- Аймгийн хэмжээнд ГХУС арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2023 онд 336.3 сая төгрөгөөр, 2024 онд 275.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөж, хуваарилсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Бусад салбар, байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, тогтоомжид торгуулийн орлогыг төлөвлөх талаар нарийвчлан тусгаагүй байна.
- Аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож, төлөвлөөгүй байна.
- Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгууль нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байна.
- Тайлант онуудад торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.
- Тайлант онуудад аймаг, сумд нь торгуулийн орлогын эх үүсвэрээс ГХУС зардалд журмын дагуу хуваарилаагүй байна.
- Тайлант онуудад ГХУС арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Торгуулийн орлогын эх үүсвэрээр ГХУСАЗСЗ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ил тод, нээлттэй мэдээлээгүй байна.
- Торгуулийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, ногдуулалт, бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын газар болон иргэн, ТББ, ОУБ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Аймаг, сумын торгуулийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож, бодитоор төлөвлөх.
- Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх.
- Аймаг, сумын ГХУС арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу тооцож төлөвлөсний үндсэн дээр хуваарилах.
- Аймаг, сумын ГХУС үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх.
- Аймаг, сумын торгуулийн орлогын ногдуулалт, бүрдүүлэлт, зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

О.АНХБАЯР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505.

Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081

Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn

Цахим хуудас: www.selenge.gov.mn

2025.08.04 № 01/1034

танай _____-ны № _____

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй.

 Н.ЛХАГВАДОРЖ